



**ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2022 оны 04 сарын 04 өдөр

Дугаар Б/15

Ховд


Х.Сарантуяад цалинтай чөлөө олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3, 16.5.5, аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2020 оны А/131 дүгээр тушаалаар баталсан “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 7 дугаар зүйлийн 7.2.3-ын “а” дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нутгийн удирдлагын ордны үйлчилгээний тасгийн үйлчлэгч Хавчигийн Сарантуяа нь Улаанбаатар хотод нарийвчилсан шинжилгээ хийлгэж, онош тодруулах зайлшгүй шаардлагаар чөлөө хүссэн тул 2022 оны 04 дүгээр сарын 04-ний өдрөөс эхлэн Хөдөлмөрийн дотоод журманд заасны дагуу ажлын 5 хоногийн цалинтай чөлөө олгосугай.

2. Х.Сарантуяаг чөлөөтэй байх хугацааны цалинг бодож олгохыг Санхүү, аж ахуйн тасгийн дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч (Б.Нямдэлгэр)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Д.ЭНХБОЛД